

Монгол Улс

**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН 2016 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

2016 оны 1 дүгээр сарын 05

2016 ОНД ДЭВШҮҮЛСЭН ЗОРИЛТ

Авлигатай тэмцэх газар нь 2016 онд Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараахь зорилтуудыг дэвшүүлж байна:

1. Авлигын эсрэг үндэсний хөтөлбөрт нийцүүлэн байгууллагын дунд хугацааны стратегийг боловсруулж, хэрэгжүүлэх;

2. Төсвийн хэмнэлтийн горимд ажиллаж байгаатай холбогдуулан хуулиар хүлээсэн чиг үүрэг, зорилтоо ханган биелүүлэхийн тулд байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хэлтэс албадын ажлын уялдаа холбоог сайжруулж, байгууллагын үйл ажиллагаа доголдолгүй, хэвийн явагдах бүхий л нөхцөлийг ханган ажиллах;

3. Авлигатай тэмцэх, хариуцлага, шударга ёсыг бэхжүүлэх үндэсний хөтөлбөртэй уялдуулан авлига, ашиг сонирхлын шалтгаан нөхцлийг арилгах арга хэмжээг цогцоор хэрэгжүүлж, шударга байдлын үнэлэмжийг

нэмэгдүүлэх, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны үр дүнг сайжруулах;

4. Мэдүүлгийн системийг сайжруулж бүрэн цахимжуулах, мэдээллийн санд үндэслэн судалгаа, дүн шинжилгээний ажлыг эрчимжүүлэх, нийтийн албанд томилогдох нэр дэвшигчийн хувийн ашиг сонирхол, ашиг сонирхлын зөрчилд өртөх эрсдлийг бууруулах, албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлэг, авлига, ашиг сонирхлын зөрчлийг хянан шалгах, шалгалтын чанар хүртээмжийг дээшлүүлэх;

5. Эрх зүйн шинэ орчинд орчин үеийн техник технологи ашиглан албан тушаалын гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах шуурхай ажиллагааг эрчимжүүлэх, ажилтнуудын ур чадварыг нэмэгдүүлэх, гэмт хэргийн шалтгаан нөхцлийг судлан, түүнээс урьдчилан сэргийлэх, арилгах арга хэмжээг бусад хэлтэс, албадтай хамтран авч хэрэгжүүлэх;

6. Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналтыг шинэ шатанд гарган, сургалтын үр өгөөжийг нэмэгдүүлж, байгууллага, албан хаагчдын аюулгүй байдлыг ханган, ая тухтай ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилтыг дэвшүүлж байна.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

БАТЛАВ

**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮН КОМИССАР Н.ГАНБОЛД**

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН 2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Нэг. Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ

Авлигатай тэмцэх, хариуцлага, шударга ёсыг бэхжүүлэх үндэсний хөтөлбөртэй уялдуулан авлига, ашиг сонирхлын шалтгаан нөхцлийг арилгах арга хэмжээг цогцоор хэрэгжүүлж, шударга байдлын үнэлэмжийг нэмэгдүүлэх, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны үр дүнг сайжруулах зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

Хөтөлбөр, хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт		Хариуцах нэгж
	Арга хэмжээ (гарц)-ний шалгуур үзүүлэлт /тоо, чанар, хугацаа/-ийн хүрэх түвшин	Хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин	
1.	2.	3.	4.
1. Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр:			
1.1.Улсын хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах, арга зүйн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих 1 багц арга хэмжээ	а/Аймаг, нийслэл 22, яамд 15, ЗГ-ын агентлаг 29, УИХ-ын 6 байгууллага, дүүрэг 9, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 84 нийт 165 байгууллагад хүрч ажиллах. б/Монгол Улсын хууль, Засгийн газрын шийдвэрээр бүтэц өөрчлөгдсөн, шинээр байгуулагдсан агентлаг, төрийн өмчит ХК, ТӨҮГ-ыг авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөтэй болгох. Жилдээ	- Мэргэжил, арга зүйн удирдлагаар хангасан байна. - Заавар, зөвлөмж хүргүүлсэн байна. - Хэрэгжилтэд нь хяналт тавьсан байна. - Олон нийтэд мэдээлсэн байна.	УССГХ
1.2.Төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагаа хариуцсан эрх бүхий албан тушаалтан /ЭБАТ/-ыг мэдээлэл арга зүйн удирдлагаар хангах, хамтран ажиллах	а/ЭБАТ/-ын үйл ажиллагааг үнэлэх үзүүлэлтэд урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг үнэлэх үнэлгээг оруулан хэрэгжүүлэх б/Төрийн байгууллага, ЭБАТ-д цахим хаягаар нь арга зүйн зөвлөгөө өгөх, мэдээлэл хүргүүлэх, хэрэгжилтэнд хяналт тавих в/Авлигын эсрэг үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүрэг чиглэл нэмэгдэхтэй уялдуулан ЭБАТ-ыг мэдээлэл арга зүйгээр хангах хөтөлбөрийн төсөл боловсруулан танилцуулах	-Авлигатай тэмцэх газар, харилцагч байгууллагуудын хамтын ажиллагаа болон эрх бүхий албан тушаалтны чадавхи сайжирна. -АЭНҮБК-ийн зохих хэсгийн хэрэгжилт хангагдана. -Авлигын эсрэг хууль тогтоомжоор хүлээсэн үүрэг хэрэгжиж, улсын хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааг нь уялдуулан	

	<p>г/Хариуцсан байгууллагуудын цахим хуудастай танилцаж, тухайн байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах чиглэлээр авч буй ажилтай танилцах, шаардлагатай тохиолдолд албан бичиг, зөвлөмж хүргүүлэх, түүний мөрөөр ажиллах</p> <p>д/НҮБ-ын Конвенцын хэрэгжилт үнэлдэг шалгуур үзүүлэлт болон хэвлэл мэдээлэл, олон нийт, хэрэглэгчийн санал бодол зэрэг гуравдагч эх сурвалж оруулахад дэмжлэг үзүүлж хамтран ажиллах</p> <p>е/2015 онд үнэлгээ хийсэн “Шинжээчдийн баг”-аас дэвшүүлсэн санал, зөвлөмжийг тусгах</p> <p>II улиралд</p>	<p>зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавих боломж бүрдэнэ.</p>	
<p>1.3.Төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааны 2015 оны үнэлгээний үр дүнгийн талаарх мэдээллийг төрийн байгууллагуудад хүргэх, “Шинжээчдийн баг”-аас ирүүлсэн Зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх 1 багц арга хэмжээ</p>	<p>а/Үнэлгээнд хамрагдсан 122 байгууллагад албан бичиг хүргүүлэх, хангалтгүй үнэлэгдсэн яам, агентлаг, шинээр байгуулагдсан байгууллагуудад тусгайлсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх.</p> <p>б/ГХЯ, БСШУЯ, БОНХАЖЯ, ЗТЯ-ны харьяа байгууллагуудад авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөх арга зүйг эзэмшүүлэх ажлыг зохион байгуулах, ЧД, БЗД-т авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцаж арга зүйн зөвлөгөөгөөр хангах.</p> <p>I/15</p>	<p>-Төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааны 2016 оны үнэлгээ 2015 оныхоос дээшилсэн байна.</p> <p>-Авлигын эсрэг хуулиар хүлээсэн үүргийн биелэлтэд ахиц гарсан байна.</p> <p>-Авлигатай тэмцэх чиглэлээр тухай байгууллагын удирдлагын хүсэл эрмэлзлэл дээшлэнэ</p>	УССГХ
<p>1.5.Авлигын эсрэг үйл ажиллагааны 2015 оны үнэлгээний үр дүнтэй холбогдуулан хөдөө, орон нутаг ажиллах 1 багц арга хэмжээ</p>	<p>а/Орон нутаг /Баян-Өлгий, Дундговь/-т ажиллах.</p> <p>в/Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн ажилтнуудыг хамруулах.</p> <p>Эхний хагас жилд</p>	<p>-Төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааны 2016 оны үнэлгээ 2015 оноос дээшилсэн байна.</p> <p>-Авлигын эсрэг хуулиар хүлээсэн үүргийн биелэлтэд ахиц дэвшил гарсан байна.</p>	УССГХ /МШХ, ХШДШХ-тэй хамтрах/
<p>1.6.Төрийн байгууллагуудаас 2016 онд хэрэгжүүлсэн авлигын эсрэг үйл ажиллагааны үр дүнг хөндлөнгийн шинжээчээр үнэлүүлэх</p>	<p>а/Авлигын эсрэг хууль тогтоомжоор хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангах.</p> <p>б/Төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлалд заасан шалгуур үзүүлэлтийг хангах</p>	<p>-Үнэлгээ үнэн бодитой гарсан байна.</p> <p>-Төрийн байгууллагын үйл ажиллагаанд иргэн, ТББ-аас хяналт тавих боломжийг олгосон байна.</p>	УССГХ

	<p>в/Төрийн болон төрийн өмчит байгууллагуудыг хамруулах.</p> <p>XI, XII сард</p>		
<p>1.7.“Монгол Улсад үндэсний шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх, авлигатай тэмцэх, хариуцлага, шударга ёсыг бэхжүүлэх” Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах</p>	<p>а/Хөтөлбөрийг иргэд, олон нийт, төрийн албан хаагчдад сурталчлах б/Хөтөлбөрт тусгасан арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх байгууллага, албан тушаалтнуудад зөвлөж, арга зүйн удирдлагаар хангах в/Сурталчилгааны материал бэлтгэж, түгээх г/Хэрэгжүүлэх арга хэмжээ бүрээр биелэлтийг гаргах д/Үр дүнг олон нийтэд мэдээлэх, дүн мэдээ, тайланг холбогдох газарт хүргүүлэх</p> <p>Батлагдсан даруйд</p>	<p>- Үндэсний хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөл боломж бүрдэнэ.</p>	УССГХ
<p>1.8.Авлига, албан тушаалын гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгахад чиглэсэн 1 багц арга хэмжээ</p>	<p>а/Монгол Улсын ОУИТБС-ын хүрээнд нутгийн захиргааны байгууллага уул уурхайн аж ахуйн нэгжүүдтэй хийх нэгдсэн гэрээг ЗГ-ын тогтоолоор батлуулахад хамтран ажиллах б/Батлан хамгаалах яамнаас санаачлан хэрэгжүүлж буй “Зэвсэгт хүчний хөгжлийн сан”-г судлан үзэх в/Шинээр батлагдсан хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу цагдаагийн албан хаагчаас ногдуулах торгууль, шийтгэврийн хэмжээ нэмэгдсэнтэй холбогдуулан тодорхой төрлийн урьдчилан сэргийлэх болон торгууль, шийтгэвэр ногдуулах эрх бүхий албан тушаалтнуудыг соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах, г/США-наас гаргасан судалгаа шинжилгээний үр дүнд тулгуурлаж, мөрдөн байцаагчийн мэдэгдэл, зөрчил арилгуулахаар хүргүүлсэн албан бичиг болон ХШДШХ-ийн хяналт шалгалтын мөрөөр ажилладаг байх д/Хэвлэл, мэдээллийн хэрэгсэл болон иргэдийн санал гомдлын мөрөөр ажилладаг байх</p> <p>Жилдээ</p>	<p>-Албан тушаалын гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнд эерэг нөлөө үзүүлсэн байна.</p>	УССГХ
<p>1.9.Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах</p>	<p>а/Конвенцын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудад санал хүргүүлэх, хамтран ажиллах б/Тайланг нэгтгэн танилцуулж орчуулах, хүргүүлэх ажлыг зохион байгуулах</p>	<p>-Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцийн дагуу хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд үр дүн гарна.</p>	УССГХ

	Жилдээ		
1.10. Авлигын эсрэг хууль тогтоомжийг суртачлах, авлигын эсрэг сургалт, мэдээллийн үйл ажиллагаа зохион байгуулах	а/Сургалтыг нэгдсэн төлөвлөгөөний дагуу зохион байгуулах б/Судалгаа, үнэлгээнд тулгуурлан салбарын онцлогийг тусгасан слайд боловсруулж сургалт хийх в/Сургалтын нэгдсэн бүртгэлийг хийж, сургалт бүрийг нарийвчлан бүртгэж байх г/Гарын авлага, видео контент, хэвлэмэл материал, зурагт хуудас, анимэйшн бэлтгэж хэвлүүлэх, түгээх ажлыг зохион байгуулах. д/Сургалтын видео материал бэлтгэх, түгээх е/Сургалтын он-лайн хэлбэрийг ашиглах эхлэлийг тавьж, хэрэгжүүлэх Жилдээ	-Төлөвлөгөөний дагуу сургалтыг зорилтот бүлгийн онцлогийг харгалзан зохион байгуулна. -Сургалтын агуулга, бэлтгэл сайжирна. -Авлигын эсрэг хууль тогтоомжийн талаарх иргэд олон нийтийн ойлголт сайжирсан байна. -Хууль тогтоомжийг суртачлах ажилд шинэ хэлбэр нэвтэрнэ. -Төсөв, цаг хугацаа хэмнэж, олон хүн хамруулах боломжтой.	УССГХ
1.11. Авлигын эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг тодорхой салбарт буюу зорилтот бүлэгт чиглүүлэн үйл ажиллагаа, аян зохион байгуулах	а/Оюутан, залууст зориулсан “Хамтдаа” сургалтын хөтөлбөрийг үргэлжүүлэх /сар бүр/ б/Барилга, боловсрол, уул уурхайн салбар болон хувийн хэвшлийнхэнд чиглэгдсэн үйл ажиллагааг зохион байгуулах в/“Туулай хүүгийн адал явдал” гарын авлагыг түгээх аяныг үргэлжлүүлэн зохион байгуулах Жилдээ	-Оюутан, залуусын авлигын эсрэг боловсрол сайжирна. -Салбарын байгууллагууд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангагдана. -Авлигын шалтгаан нөхцлийг бууруулах, авлигатай тэмцэх хүсэл зоригийг нэмэгдүүлэх, хүүхэд, залуучуудын шударга байдлын түвшин өсч, шударга ёс төлөвшинэ.	УССГХ
1.12.Зорилтот бүлгүүдэд авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, соён гэгээрүүлэхэд чиглэсэн 1 багц арга хэмжээ	а/Мэтгэлцээн, онол арга зүйн бага хурал, зурагт хуудас тус тус бэлтгэж боловсруулах, хэвлүүлэх. Жилдээ	-Зорилтот бүлгийн авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэлийг дэмжих, олон нийтийн мэдлэг дээшилнэ.	УССГХ
1.13.Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Авлигын эсрэг сүлжээний үнэлгээний ажилд оролцох	а/3 дугаар шатны мониторингийн асуулгыг орчуулж, холбогдох байгууллагуудад хүргүүлэх; б/Уг асуулгад Авлигатай тэмцэх газартай холбоотой мэдээллийг боловсруулж хариулах; в/Холбогдох хууль, тогтоомж орчуулах ажлыг зохион байгуулах. 3-6 сар, 9-11 сар	3 дугаар шатны мониторингийн тайлан бэлтгэгдэн гарсан байна.	УССГХ
1.14.Сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн арга хэмжээ	а/Шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулах, олон улсын туршлагыг судлах, албажуулах б/2016 онд шалгарсан сайн туршлагыг төрийн болон төрийн өмчит хуулийн этгээдүүдэд сурталчлах ажлыг зохион байгуулах	-Авлигатай тэмцэх санал, санаачилга нэмэгдэнэ. -Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд ахиц гарна.	УССГХ

	<p>в/2015 онд шалгарсан сайн туршлагыг сурталчлах /ЭБАТ-ны үйл ажиллагаа “Туршлагаа хуваалцъя” арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх/ г/“Шилдэгээр шалгарсан ЭБАТ-уудтай ярилцлага хийлгэж, ажлын сайн туршлагыг сурталчлах ажлыг зохион байгуулах</p> <p>Жилдээ</p>		
<p>1.15.Олон нийтэд авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, тэдэнд авлигыг үл тэвчих ёс суртахуун төлөвшүүлэх зорилгоор “hamtdaa.mn” цахим хуудас, фэйсбүүк хуудсыг тогтмол ажиллуулж, холбогдох журмыг боловсруулж батлуулах</p>	<p>а/Авлигын хор хөнөөлийг олон нийтэд ойлгуулах, соён гэгээрүүлэхэд чиглэх б/Хүүхэд, залуучуудыг авлигын эсрэг үйл ажиллагаанд татан оролцуулах. в/Сайн дурын хөдөлгөөнийг дэмжихэд чиглүүлэх.</p> <p>Жилдээ</p>	<p>-Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд оролцох хүүхэд, залуучуудын идэвх сайжирсан байна. -Авлигын хор хөнөөлийн талаарх мэдээлэл сайжирсан байна.</p>	УССГХ
<p>1.16.Дэлхийн банкны төслийн үйл ажиллагааг эрчимжүүлж, төлөвлөсөн ажлуудыг хэрэгжүүлэхэд оролцох, зохицуулалт хийх</p>	<p>а/Интернет модем, IBM корпорациас програм хангамж тус тус худалдан авах б/ХАСХОМ-ийн програм хангамжийг сайжруулах зөвлөх компанитай гэрээ байгуулж, ажлыг гүйцэтгүүлэх в/ЭБАТ-ын сургалтыг зохион байгуулах г/Шударга байдлын түвшний тухай судалгааны аргачлалыг сайжруулах асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулж, туршилт судалгаа явуулах.</p> <p>Жилдээ</p>	<p>-Төлөвлөгөөт ажлууд зохион байгуулагдаж дууссан байна.</p>	<p>УССГХ /ХШДШХ, США-тай хамтрах/</p>
<p>1.17.Авлигын эсрэг олон улсын өдөр /12-р сарын 09/-ийг угтан зохион байгуулах арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах</p>	<p>а/Зохион байгуулах арга хэмжээний үр дүнг тооцон төлөвлөх, батлуулах б/Шаардагдах төсөв, зардлыг тооцсон байх в/Төлөвлөгөөний дагуу ажиллах, үр дүнг танилцуулах г/НҮБ-аас Авлигын эсрэг олон улсын өдрийг угтан зарладаг тэтгэлэгт төсөл бичиж оролцох</p> <p>III, IV улирал</p>	<p>-Уламжлал болгон зохион байгуулдаг арга хэмжээг иргэд олон нийтэд таниулах, гаргасан шинэ санал санаачилга, туршлагыг урамшуулах замаар оролцоог нэмэгдүүлж авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын үр нөлөөг дээшлүүлнэ</p>	УССГХ

Хоёр. Судалгаа шинжилгээний чиглэлээр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ

Аливаа судалгаа шинжилгээг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлал, арга зүйн дагуу цахим технологид тулгуурлан, мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэж, үр дүнг авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг оновчтой төлөвлөн хэрэгжүүлэхэд ашиглах, зөвлөмжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх замаар судалгааны ач холбогдлыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

2. Судалгаа шинжилгээний чиглэлээр:

1.	2.	3.	5.
<p>2.1.Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдлын талаар УИХ-д хүргүүлэх мэдээлэл /2015 он/-ийг бэлтгэх арга хэмжээ</p>	<p>Хэлтэс, албадын үйл ажиллагааны тайлан, дотоодын болон гадаадын судалгааны үр дүнг судлан мэдээлэл бэлтгэх</p> <p>2-4 дүгээр сард</p>	<p>Мэдээллийг тогтоосон хугацаанд хүргүүлсэн байна.</p>	<p>США</p>
<p>2.2.Дүн шинжилгээ хийх 1 багц арга хэмжээ</p>	<p>а/Өргөдөл, гомдол, мэдээлэл, тэдгээрийг шийдвэрлэх үйл ажиллагаа. б/Шүүхээр шийдвэрлэгдсэн авлигын хэргийн мэдээлэл в/ХАСУМ болон нийтийн албан тушаалтанд албан үүрэгтэй нь холбогдолгүй өгсөн бэлгийн тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийх</p> <p>Сар бүрийн 20-ны дотор</p>	<p>Дүн шинжилгээ хийж тайланг удирдлагад танилцуулсан байна.</p>	<p>США</p>
<p>2.3.Мэдээ, танилцуулга бэлтгэх, мэдээллийн сан үүсгэх, авлига нөхцөл байдлын тойм эмхтгэл гаргах, тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийх, шинээр батлагдсан болон хэлэлцэгдэж байгаа журам, хуулийн төслийн талаар танилцуулга бэлтгэх багц ажил</p>	<p>а/Шүүхээр шийдвэрлэгдсэн авлигын хэргийн талаар мэдээллийн сан үүсгэх. б/Гадаад мэдээний тойм бэлтгэж танилцуулах в/Гадаад улс орнуудын авлига нөхцөл байлын тойм бэлтгэх. г/Авлигын нөхцөл байдлын талаар олон улсын болон дотоодын байгууллагын гүйцэтгэсэн судалгаа, дүн шинжилгээнд үндэслэн танилцуулга бэлтгэх д/Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх ажлын хүрээнд хэлтэс, албадын танилцуулга бэлтгэх</p> <p>Жилдээ</p>	<p>Шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох хэлтэс, албадтай мэдээлэл солилцож, хамтарч ажилласан байна.</p> <p>Танилцуулга, санал бэлтгэгдэж хугацаандаа хүргэгдсэн байна</p>	<p>США</p>
<p>2.4.Шударга байдлын үнэлгээ хийх 1 багц арга хэмжээ</p>	<p>а/Шударга байдлын 2015 оны үнэлгээгээр хангалтгүй гарсан байгууллагуудын тоон мэдээлэл үндэслэн танилцуулга бэлтгэх. б/Шударга байдлын үнэлгээний 2016 оны судалгааны бэлтгэл ажлыг хангаж, мэдээлэл цуглуулах ажлыг зохион байгуулах Шударга байдлын үнэлгээний 2015 оны үр дүнг үндэслэн танилцуулга, тайлан бэлтгэн хэвлүүлэх.</p> <p>Жилдээ</p>	<p>-Шударга байдлын үнэлгээг тооцон гаргасан байна.</p> <p>-Судалгааны үр дүнгээр тайлан бэлтгэж хэвлэсэн байна.</p> <p>-Мэдээлэл цуглуулах байгууллагыг сонгон шалгаруулж, мэдээллийг цуглуулсан байна.</p>	<p>США</p>

2.5.Бусад судалгааны ажлын чиглэлээр	а/"Survey monkey" программын эрхийг сунгах, судалгаанд ашиглах /Улирал бүр тогтмол/ б/Худалдах авах ажиллагааны байгууллага болон боловсрол, эрүүл мэндийн салбарын авлигын эрсдэл бүхий ажлын байр, удирдах алба хаагчдын авлигын хандлагыг тодорхойлох судалгааг зохион байгуулах /III улиралд/ д/"Шударга ёс" сэтгүүлийг эрхлэн гаргах	Программыг судалгааны мэдээлэл цуглуулах ажилд ашигласан байна. Судалгааны мэдээлэл цуглуулагдсан байна. Олон нийтэд тараасан байна.	США
2.6.Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын төсөөллийн судалгаа, Хүүхдийн шударга байдлыг үнэлэх судалгааг зохион байгуулж, үр дүнг нийтэд мэдээлэх 1 багц арга хэмжээ	а/Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын төсөөллийн 2015 оны судалгааны тайланг олон нийтэд болон холбогдох байгууллагын төлөөлөлд танилцуулах. б/Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн 2016 оны судалгаа зохион байгуулах в/Хүүхдийн шударга байдлын түвшинг үнэлэх судалгаа явуулах. д/Судалгаануудын тайланг хэвлүүлэх. Жилдээ	-Судалгааны үр дүнг танилцуулсан байна. -Судалгааны мэдээлэл цуглуулагдсан байна.	США

Гурав. Хяналт шалгалт, дүн шинжилгээний чиглэлээр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ

Мэдүүлгийн системийг сайжруулж бүрэн цахимжуулах, мэдээллийн санд үндэслэн судалгаа, дүн шинжилгээний ажлыг эрчимжүүлэх, нийтийн албанд томилогдох нэр дэвшигчийн хувийн ашиг сонирхол, ашиг сонирхлын зөрчилд өртөх эрсдлийг бууруулах, албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлэг, авлига, ашиг сонирхлын зөрчлийг хянан шалгах, шалгалтын чанар хүртээмжийг дээшлүүлэх зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

1.	2.	3.	5.
3. Хяналт шалгалт, дүн шинжилгээний чиглэлээр Мэдүүлгийн бүрдүүлэлт, дүн шинжилгээний чиглэлээр:			
3.1.ХАСХОМ-ийн 2015 оны бүрдүүлэлтийн ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах 1 багц арга хэмжээ	а/Авлигатай тэмцэх газарт ХАСХОМ-ээ мэдүүлэх төрийн өндөр албан тушаалтан болон түүнтэй адилтгах албан тушаалтны мэдүүлгийг хуулийн хугацаанд бүртгэх ажлыг зохион байгуулах. б/Төрийн захиргааны болон нутгийн захиргааны 111 байгууллагаас хуулийн үйлчлэлд хамаарах мэдүүлэг гаргагчдын нэрсийн жагсаалтыг гаргуулан авах, хяналт тавих ажлыг зохион байгуулах. в/Авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйлийн 13.8, 11 дүгээр зүйлийн 11.1.1 болон журмын 5-д заасан чиг үүргийг тус тус хэрэгжүүлэх	-Мэдүүлгийн бүрдүүлэлтийн тайлангийн ХАСХОМ гаргавал зохих мэдүүлэг гаргагчдын тоо нь нэрсийн жагсаалтын тооноос 2 хувиас хэтрэхгүй байх. -Эрх бүхий албан тушаалтны мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааны зөрчил багасч, мэдүүлгийн үнэн зөв, бодит байдал дээшилсэн байх, ЭБАТ-ын судалгааг улирал бүр гаргасан байна.	ХШДШХ

	Жилдээ	-Авлигатай тэмцэх газарт мэдүүлгээ бүртгүүлэх албан тушаалтнаас ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд бүртгэсэн байна.	
3.2.Мэдүүлэг гаргагч болон эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан сургалт, сурталчилгааны 1 багц арга хэмжээ	<p>а/Төрийн захиргааны болон нутгийн захиргааны төв 111 байгууллагын эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан сургалт зохион байгуулах.</p> <p>б/Гадаад улс орнууд, олон улсын байгууллагуудын туршлагыг судлах, олон улсад зохиогдож буй уулзалт, сургалтуудад оролцох, хамтран ажиллах арга хэмжээг зохион байгуулах.</p> <p>в/АТГ-т мэдүүлгээ бүртгүүлэх төрийн өндөр албан тушаалтнуудын мэдүүлгийн хураангуйг нэгтгэн “Төрийн мэдээлэл” эмхтгэлд хэвлэн нийтлэх болон тус газрын www.xacxom.iaac.mn цахим хуудсанд байршуулах.</p> <p>Жилдээ</p>	<p>-Сургалтад хамрагдсан албан хаагчдын мэдлэг дээшилсэн байна.</p> <p>-Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээд болон мэдүүлэг гаргагч нарын хууль тогтоомжийн талаарх мэдлэг дээшилсэн байна.</p> <p>-Төрийн өндөр болон түүнтэй адилтгах албан тушаалтны мэдүүлгийн хураангуйг олон нийтэд ил тод болгож мэдээлэл авах боломжтой болсон байна.</p> <p>-Мэргэшсэн эрх бүхий албан тушаалтантай болно.</p> <p>-Уулзалт, сургалтад шинээр томилогдсон эрх бүхий албан тушаалтнуудыг бүрэн хамруулсан байна.</p>	ХШДШХ
3.3.ХАСХОМ-ийн бүрдүүлэлтийн ажлын мөрөөр авах 1 багц арга хэмжээ	<p>а/Мэдүүлэг гаргагчдын хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлт, явц байдлыг танилцуулах тойм мэдээг бэлтгэн Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хүргүүлэх.</p> <p>б/ХАСХОМ-ээ гаргаагүй, гаргаж өгөхөөс татгалзсан, эсхүл хугацаа хожимдуулж бүртгүүлсэн албан тушаалтанд хариуцлага тооцуулах, ХАСХОМ-ийг нөхөн гаргуулах.</p> <p>в/Хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангаж, ХАСХОМ-ийн бүртгэл, хадгалалт хамгаалалт, тайлагнах ажлын явц байдалд хяналт тавин, үнэлэлт дүгнэлт өгч, цаашид авах арга хэмжээг тодорхойлон хэрэгжүүлэх.</p> <p>г/ХАСХОМ-ийн бүрдүүлэлтийн хяналт шалгалтын хуваарийг батлуулж, хяналт шалгалтын үйл ажиллагааг явуулах.</p> <p>Жилдээ</p>	<p>Мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааны талаар болон тайлангийн тоо мэдээг холбогдох байгууллагад хүргүүлж мэдээллээр хангасан байна.</p> <p>-Мэдүүлгийн 2014 оны бүрдүүлэлтийн тоо /11/-ноос багагүй байна. Бүрдүүлэлтийн хувь 99,99 хувиас буураагүй байна.</p> <p>-Мэдүүлгийн бүрдүүлэлттэй холбоотой хууль, журмын хэрэгжилт хангагдсан байх</p> <p>-2015 онд бүрдүүлэлтийн хяналт шалгалтад хамрагдсан төрийн захиргааны болон тэдгээрийн салбар нэгжийн 76 байгууллагын тооноос багагүй байна.</p>	ХШДШХ
3.4.“Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн мэдээллийн систем”-ийг хэвийн ажиллах нөхцлийг хангаж ажиллах	<p>а/Систем-ээс алдаа өгөгдлийг шүүж илрүүлэн, алдааг засч, шаардлагатай арга хэмжээг шуурхай авч ажиллах.</p> <p>б/Систем-ээс ХАСХОМ-2 тайлан гаргах нөхцлийг хангаж ажиллах.</p> <p>Жилдээ</p>		ХШДШХ

Хяналт шалгалтын чиглэлээр:			
3.5.Нийтийн албанд томилог-дохоор нэр дэвшсэн этгээдийн урьдчилсан мэдүүлгийг хуульд заасны дагуу хянаж, хариу өгөх 1 багц арга хэмжээ	а/10000 хүртэл албан тушаалтан хамрагдах. Жилдээ	Хуульд заасан хугацаанд урьдчилсан мэдүүлгийг хянасан байна.	ХШДШХ
3.6.Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг төлөвлөгөөт хуваарь болон иргэдийн гомдол, мэдээлэл, бусад төлөвлөгөөт бус шалгалтын дагуу хянан шалгах 1 багц арга хэмжээ	б//550 хүртэлх этгээдийн мэдүүлгийг төлөвлөгөөт хуваарь болон иргэдийн гомдол, мэдээлэл, бусад төлөвлөгөөт бус шалгалтын дагуу хянан шалгах. б/380 хүртэлх өргөдөл, гомдол, мэдээллийг хууль, журамд заасан шаардлагад нийцүүлэн хянан шийдвэрлэх. в/Хяналт шалгалтаар илэрсэн 150 хүртэл зөрчил, дутагдлыг арилгуулах, хариуцлага тооцуулах асуудлыг холбогдох албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх. Жилдээ	-Хянан шалгах өргөдөл, гомдлын тоо өмнөх оны түвшнээс багагүй байна. -Сүүлийн 7 жилийн судалгаа, авлигын индексийн судалгаанд үндэслэн хяналт шалгалтын хуваарийг батлуулан шалгасан байна. Өмнөх оноос 11,3 хувиар нэмэгдэнэ -Хуулийн хэрэгжилтийг хангаж, зөрчил, дутагдлыг арилгана.	ХШДШХ
3.7.Дүн шинжилгээний ажил	а/Хяналт шалгалтын үр дүнд илэрсэн хууль, эрх зүйн зөрчлийг мэдүүлэг гаргагчдын байгуулага, салбар бүрээр судлан шинжилж авлигын эсрэг үйл ажиллагаанд хэрэглэх. Хагас жилд б/ ЭБАТ-ны үйл ажиллагаа, хууль тогтоомжийг хэрэгжүүлсэн байдалд дүн шинжилгээ хийх, дүгнэлт гаргах, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авах. Улирал бүр	Хяналт шалгалтыг шуурхай гүйцэтгэх боломж бүрдсэн байна. -Эрх бүхий албан тушаалтнуудын үйл ажиллагаа, тайлан мэдээний үнэн бодит байдлыг “Үнэлгээний хуудас”-аар үнэлж дүгнэсэн байна.	ХШДШХ

Дөрөв. Мөрдөн шалгах үйл ажиллагаа хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ

Эрх зүйн шинэ орчинд орчин үеийн техник технологи ашиглан авлига, албан тушаалын гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах шуурхай ажиллагааг хэвшүүлж, ажилтнуудын чадварыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

4. Мөрдөн шалгах чиглэлээр:				
1.	2.	3.	4.	5.

<p>4.1.Иргэд, хуулийн этгээдээс ирүүлсэн гомдол, мэдээллийг шалгаж шийдвэрлэх чиглэлээр хэрэгжүүлэх 1 багц арга хэмжээ</p>	<p>Гомдол, мэдээллийг хуулийн хугацаанд /5-19 хоног/, хуульд заасан үндэслэл журмын дагуу шийдвэрлэх. -Хүлээн авсан гомдол, мэдээллийн 98 хувийг 2016 онд багтааж шийдвэрлэх. Жилдээ</p>	<p>-100 хувь хуулийн хугацаанд, 98 хувийг нь 2016 ондоо багтааж шийдвэрлэсэн байна.</p>	<p>МШХ</p>
<p>4.2.Мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан эрүүгийн хэргийг хуульд заасан үндэслэлээр шийдвэрлүүлэх 1 багц арга хэмжээ</p>	<p>-Эрүүгийн хэрэгт хугацаа авах ажиллагааг 2015 оныхоос 5 хувиар бууруулах. -Прокурор шүүхээс эрүүгийн хэрэг нэмэлт мөрдөн байцаалтанд буцахыг 20 хувиар бууруулах. Жилдээ</p>	<p>-Мөрдөн байцаалт явуулсан нийт хэргийн 30 хувийг үндсэн хугацаанд шийдвэрлэх. -Прокурор шүүхийн гологдлыг өмнөх оныхоос 20 хувиар бууруулах.</p>	<p>МШХ</p>
<p>4.3.Нуугдмал эд хөрөнгийг олж илрүүлэх арга хэмжээ авах 1 багц арга хэмжээ</p>	<p>Албан тушаал, хээл хахууль, ашиглалын хэрэгт холбогдсон этгээдүүдийн гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгө, мөнгийг нэг бүрчлэн тогтоох. Жилдээ</p>	<p>Хохирол барагдуулалтыг 2015 оныхоос 10 хувь нэмэгдүүлсэн байна.</p>	<p>МШХ</p>
<p>4.4.Нотлох баримт цуглуулах, нотлох үйл ажиллагааг хэрэгжүүлэх 1 багц арга хэмжээ</p>	<p>-Эрүүгийн хэргийг шийдвэрлэхэд ач холбогдол бүхий зайлшгүй шаардлагатай нотлох баримт цуглуулахад үйл ажиллагааг чиглүүлэх, -Нотлох үйл ажиллагааны арга техник, ур чадварыг сайжруулах, -Нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх үйл ажиллагаанд хууль зөрчөөгүй байх, -Овор ихтэй, битүүмжлэгдсэн, эд мөрийн баримтаар хураагдсан автомашин, эд зүйлийг хадгалуулах -Үнэт зүйлийг хадгалуулах Жилдээ</p>	<p>-Нотлох баримт дутуу, хуульд заасан үндэслэл журмаар бэхжүүлээгүй гэх үндэслэлээр эрүүгийн хэрэг прокурор, шүүхээс буцахыг 5 хувь бууруулах, -Эрүүгийн хэргийн материалыг 100 хувь хуульд заасан журмын дагуу бэхжүүлсэн байх,</p>	<p>МШХ</p>
<p>4.5. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хохирогч иргэний нэхэмжлэгч, түүний төлөөлөгч, гэрч, хэлмэрч, орчуулагч бусад мэргэжилтэнг татан оролцуулах</p>	<p>-Эрүүгийн хэргийн гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгчийг бүрэн тогтоох, байцаан шийтгэх ажиллагаанд оролцох нөхцөлөөр хангах, -Хэлмэрч, орчуулагч, бусад мэргэжилтэнг хуульд заасан эрх, үүргээр ханган оролцуулах Жилдээ</p>	<p>-Зохих гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч нарыг бүрэн тогтоож ЭБША-д оролцуулсан байна. -Хуульд заасан тохиолдлуудад хэлмэрч, орчуулагч, мэргэжилтэнг 100 хувь оролцуулсан байна.</p>	<p>МШХ</p>
<p>4.6.Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд шинжээч нарыг татан оролцуулах</p>	<p>-Шүүх нягтлан бодох бүртгэл, санхүүгийн шинжээч нарыг байцаан шийтгэх ажиллагаанд томилж оролцуулах,</p>	<p>-Мөрдөн байцаагчийн үйл ажиллагаанаас хамаарч</p>	

	<p>-Шинжилгээнд шаардлагатай баримт, сэлтийг шуурхай гарган өгч, шинжилгээ хийх нөхцлөөр бүрэн хангах,</p> <p>-Шинжээч хууль бус дүгнэлт гаргахгүй байх, дүгнэлт нь бодитой, үндэслэлтэй байх шаардлагыг хангуулах</p> <p>Жилдээ</p>	<p>шинжээчийн дүгнэлт удаашрахгүй байх нөхцлийг хангах,</p> <p>-Зайлшгүй шаардлагатай тохиолдолд ЭБША-д шинжээчийг оролцуулсан байх,</p> <p>-Шинжээчид хуульд заасан эрх, үүргийг бүрэн танилцуулж, дүгнэлт эргэлзээгүй бүрэн байх нөхцлийг хангах.</p>	МШХ
4.7.Гэрч хохирогчийг хамгаалах	<p>-Эрүүгийн хэргийн гэрч, хохирогч, мэдээлэгч, дүгнэлт гаргасан шинжээч нарыг хохирох нөхцлийг гаргуулахгүй байх,</p> <p>-Мөрдөн байцаагчийн үйл ажиллагаанаас хамаарч гэрч, хохирогч, мэдээлэгч чирэгдэхгүй байх,</p> <p>-Гэрч, хохирогч бусдын нөлөөнд автах, худал мэдүүлэх, зайлсхийх явдлыг таслан зогсоох бүхий л арга хэмжээг авах</p> <p>Жилдээ</p>	<p>Гэрч хохирогчийг байцаахдаа ЭБШХ-ийн 147 дугаар зүйлийг баримтлах, чирэгдүүлэхгүй, залхаахгүй байх,</p> <p>-Гэрч, хохирогч, мэдээлэгчийг хууль бусаар хохироосон этгээдэд заавал хариуцлага тооцуулж, эрхийг нь хамгаалсан байх,</p> <p>-Гэрч, хохирогчид нөлөөлсөн этгээд, худал мэдүүлсэн, зайлсхийсэн тохиолдлыг</p> <p>-Гэрч, хохирогчид нөлөөлсөн этгээд, худал мэдүүлсэн, зайлсхийсэн зохих хариуцлагагүйгээр өнгөрөөхгүй байх.</p>	МШХ
4.8.Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх	<p>-Мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан эрүүгийн хэрэгт гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг бүрэн, гүйцэд тогтоох,</p> <p>-Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, иргэний нэхэмжлийг хангах нөхцлийг бүрдүүлж, эд хөрөнгө битүүмжлэх, данс царцаах арга хэмжээ авах.</p> <p>Жилдээ</p>	<p>-Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг 100 хувь тогтоосон байна.</p>	МШХ
4.9.Түдгэлзүүлсэн хэрэг нэг бүрийг хэлтэс, албаны даргад танилцуулж, хэрхэн шийдвэрлэх талаар ярилцан төлөвлөгөө гарган, үр дүнг тооцож ажиллах.	<p>Мөрдөн байцаалтын ажиллагааг түдгэлзүүлсэн эрүүгийн хэргүүдийн түдгэлзүүлсэн үндэслэлийг хянан, сэргээн шалгах, түдгэлзүүлсэн хэргийн шийдвэрлэлтэд ахиц гаргах.</p> <p>Жилдээ</p>	<p>Мөрдөн байцаалтын ажиллагааг нь түдгэлзүүлсэн эрүүгийн хэргийн түдгэлзүүлсэн үндэслэлийг хянасан, эзэн холбогдогч нь оргон зайлснаар түдгэлзүүлсэн хэргийн тоог бууруулсан байна.</p>	МШХ

<p>4.10. Гүйцэтгэх албатай хамтран ажиллаж, тэдгээрийн туслалцаа дэмжлэгийг авч, мөрдөн байцаагчийн даалгавар хүргүүлэн, үр дүнг тухай бүр тооцон ажиллах.</p>	<p>-Нууц далд аргаар үйлдэгдсэн эрүүгийн хэргийн илрүүлэлтэд Гүйцэтгэх албаны хүн хүч, техник хэрэгслийг бүрэн ашигласан байх.</p> <p>-Эрүүгийн хэргийг Гүйцэтгэх албатай хамтран шалгах ажлыг зохион байгуулах, хуульч шуурхай ажиллагааг эрхэмлэж, салбар нэгжүүдийн хамтын ажиллагааны уяалдаа холбоог сайжруулах.</p> <p>Жилдээ</p>	<p>-Мөрдөн байцаагч нар Гүйцэтгэх албанд бичсэн даалгаварынхаа заалт нэг бүрээр хариу авч Эрүүгийн хэрэгт нотлох баримт болгон ашигласан байх,</p> <p>-Эрүүгийн хэргийг илрүүлэхэд ахиц гарч 2016 онд дэвшүүлсэн зорилт амжилттай хэрэгжинэ</p>	
<p>4.11. Эрүүгийн хэргийн эрэн сурвалжилтын ажлыг чанартай хийж гүйцэтгэх.</p>	<p>-Мөрдөн байцаалтын ажиллагааг түдгэлзүүлсэн эрүүгийн хэргүүдийн түдгэлзүүлсэн үндэслэлийг хянан, сэргээн шалгаж түдгэлзүүлсэн хэргийн шийдвэрлэлтэд ахиц гаргах.</p> <p>-Сэжигтэн, яллагдагч, гэрч хохирогчийг мөрдөн байцаалтанд албадан ирүүлэх, хуяглан хүргэх.</p> <p>Жилдээ</p>	<p>Мөрдөн байцаалтын ажиллагааг нь түдгэлзүүлсэн эрүүгийн хэргийн түдгэлзүүлсэн үндэслэл нэг бүрийг хянах, эзэн холбогдогч нь оргон зайлснаар түдгэлзүүлсэн хэргийн тоог бууруулсан байна.</p>	<p>МШХ</p>
<p>4.12. УССГХ, ХШДШХ-тэй хамтарсан зөвлөгөөн зохион байгуулах</p>	<p>-Шалгасан өргөдөл, гомдол, мэдээлэл, эрүүгийн хэргийн шалтгаан нөхцлийн талаар УССГХ, ХШДШХ-тэй хамтарсан зөвлөгөөнийг зохион байгуулах</p> <p>Жилд 2-оос доошгүй удаа</p>	<p>- АТГ-ын алба хаагчид шалгасан өргөдөл, гомдол, мэдээлэл, эрүүгийн хэргийн шалтгаан нөхцөл байдал, шалгагдсан салбарын талаар тодорхой ойлголттой болох</p>	<p>Хэлтэс, албаны дарга нар</p>
<p>4.13. Авлига, албан тушаалын гэмт хэргийн эрсдэл, нөхцөл байдлын талаар сургалт зохион байгуулах</p>	<p>-Монгол Улс дахь авлига, албан тушаалын гэмт хэргийн эрсдэл, нөхцөл байдлын талаар судлаач, туршлагатай эдийн засагчаар тодорхой сэдвүүдээр хичээл, сургалт зохион байгуулах</p> <p>Улирал бүр</p>	<p>-Авлига, албан тушаалын гэмт хэргийн эрсдэл, нөхцөл байдлын талаар илүү мэдлэгтэй болох</p>	<p>Хэлтсийн дарга Тамгын хэлтэс</p>

Тав. Удирдлага, зохион байгуулалт, дотоод ажлын чиглэлээр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ

Төсвийн хэмнэлтийн горимд ажиллаж байгаатай холбогдуулан хуулиар хүлээсэн чиг үүрэг, зорилтоо ханган биелүүлэхийн тулд байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналтыг шинэ шатанд гарган, сургалтын үр өгөөжийг нэмэгдүүлж, байгууллага, албан хаагчдын аюулгүй байдлыг ханган, ая тухтай ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

5. Захиргаа удирдлага, хүний нөөц, дотоод ажил, гадаад харилцаа, хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах чиглэлээр:

1.	2.	3.	5.
5.4.Хүний нөөцийн удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ	<p>а/Байгууллагын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр боловсруулах</p> <p>б/Байгууллагын хүний нөөцийн програмтай болох.</p> <p>1 дүгээр улиралд</p> <p>в/Албан хаагчдын хууль, эрх зүйн мэдлэгийн болон бие бялдрын түвшин тогтоох шалгалтыг зохион байгуулах</p> <p>4 сард</p>	<p>-Хүний нөөцийн хөгжил, сургалтын хөтөлбөр батлагдсан байна.</p> <p>-Байгууллагын хүний нөөцийн бүрэлдэхүүн хөдөлгөөн, шагнал, шийтгэл, удаан жил болон бусад мэдээлэл програмд орсон байна.</p> <p>-Албан хаагчдын эрх зүйн мэдлэг, ур чадвар дээшилсэн байна.</p>	ТХ
5.5.Авлигатай тэмцэх газрын албан хаагчдын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой багц арга хэмжээ	<p>а/Батлагдсан сургалтын төлөвлөгөөний дагуу ур чадварыг нэмэгдүүлэх, мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулах</p> <p>б/Шинээр ажилд орох хүсэлт гаргасан төрийн албан хаагч болон иргэдийн талаар удирдлагад танилцуулах, шалгалт авах, шинээр томилогдсон албан хаагчдыг тангараг өргүүлэх ажлыг зохион байгуулах.</p> <p>в/Дотоод томилолтоор ажиллах</p> <p>г/Албан хаагчдын бэлэн байдлын хангах, чийрэгжүүлэлтийн арга хэмжээ зохион байгуулах</p> <p>Жилдээ</p>	<p>-Хүний нөөцийн чадавхи сайжирсан байна.</p> <p>-Сургалтыг ажилтнуудын мэдлэг, мэргэжлийн ур чадварыг сайжруулж чадахуйц хэмжээнд чанарын өндөр түвшинд зохион байгуулсан байна.</p> <p>-Шаардлага бүрэн хангасан чадварлаг боловсон хүчнээр сул орон тоог нөхсөн байна.</p> <p>-Алслагдмал сум, дүүргийн иргэдтэй хийх нүүр тулсан уулзалт үр дүнтэй болсон байна.</p>	ТХ ТХ ТХ
5.6.Дотоод аудитын чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ	<p>Дотоод аудитыг байгууллагын үйл ажиллагаанд бүхэлд нь хэрэгжүүлэх.</p> <p>Жилдээ</p>	<p>Байгууллагын санхүү, аж ахуйн үйл ажиллагаа, шилэн дансны хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хэрэгжсэн байна.</p>	ТХ
5.8.Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах чиглэлээр хэрэгжүүлэх 1 багц арга хэмжээ	<p>а/“Авлигатай тэмцэх газрын хэвлэл, олон нийттэй харилцах журам”-ыг боловсруулах, батлуулах.</p> <p>б/Авлигатай тэмцэх газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар болон цаг үеийн мэдээ, мэдээллийг олон нийтэд үнэн бодитой, шуурхай хүргэх.</p> <p>в/Авлигатай тэмцэх газрын (social networking) нийгмийн сүлжээг хөтлөн явуулах, өдөр тутмын сонин, сэтгүүл болон цахим орчинд тодорхой сэдэв сонгон хэлэлцүүлэг зохион байгуулах, тогтмол булан ажиллуулах.</p> <p>г/Авлигын эсрэг олон улсын академийн үйл ажиллагаа, үзэл санааг олон нийтэд сурталчлан мэдээлэх, хэлтэс, албадын чиг үүрэг, үйл</p>	<p>-Журмыг батлуулан мөрдсөн байна.</p> <p>-Нийтлэлийг өдөр тутмын сонингоор, нэвтрүүлгийг телевизээр цацаж олон нийтэд хүргэсэн байна.</p> <p>-Өдөр тутмын сонин, сэтгүүлд хэвлэсэн, цахим хуудсанд байрлуулсан байна.-Нийгмийн сүлжээ (Twitter, Facebook г.м)-г хөтлөн явуулж, тогтмол мэдээ, мэдээлэл оруулсан байна.-Өдөр тутмын сонин, сэтгүүл болон цахим орчинд тодорхой сэдэв сонгон хэлэлцүүлэг зохион байгуулсан байна.</p>	ТХ

	ажиллагаатай холбоотой нийтлэл, нэвтрүүлэг бэлтгэх, мэдээллийн электрон самбар ажиллуулах. д/Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны талаар үнэн бодит мэдээллийг хүргэх нийгмийн бүлгүүдийн уулзалтыг зохион байгуулах. Жилдээ	-Сэтгүүлч, сурвалжлагч, нийтлэлч, орон нутгийн иргэдэд чиглэсэн уулзалтыг шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулсан байна.	
Санхүү, аж ахуйн чиглэлээр			
5.9.Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажиллах	Хуулийн дагуу олон нийтэд ил болгох мэдээллийг цахим хуудсанд тогтмол оруулах. Жилдээ	Үнэн зөв, бодитой, тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлсэн байна	ТХ
5.10.2016 онд баталсан урсгал зардлын төсвийн санхүүжилтийг сар бүрийн хуваарийн дагуу зарцуулах	Зардлыг санхүүжилтийн хуваариар ангилан зарцуулах. Хуулийн хугацаанд	Авлигын эсрэг, авлигатай тэмцэх үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулах нөхцөл бүрдсэн байна.	ТХ
5.11. 2017 оны урсгал болон хөрөнгө оруулалтын зардлын талаар хэлтэс, албадаас ирүүлсэн саналыг үндэслэн төсвийн төсөөллийг боловсруулж, төсвийн хязгаарт багтааж холбогдох газарт хүргүүлэх	Зардлын төсөөллийг урьдчилан зүйл бүрээр боловсруулж, батлагдсан маягтын дагуу тайлбар тодруулгын хамт гаргах Хуулийн хугацаанд	Газрын алба хаагчдын ажиллах нөхцөл сайжирч, ажлын үр дүн, өгөөж дээшилсэн байна.	ТХ
5.12. 2016 оны баталсан урсгал зардлын төсвийн хуваарийг жил, улирал, сараар тус тус гаргаж хүргүүлэх	Зардлыг ангиллаар хуваарилж зарцуулах, гүйцэтгэлтэй уялдуулан зохион байгуулах ХII/5-ны дотор	Авлигын эсрэг, авлигатай тэмцэх үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулах нөхцөл бүрдсэн байна.	ТХ
5.13. Төсвийн шууд захирагчийн болон ерөнхийлөн захирагчийн 2015 оны жилийн эцсийн болон 2016 оны эхний хагас жилийн санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд гаргаж хүргүүлэх	а/ Холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартын дагуу анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг хөтөлж, тайланг санхүүгийн програмаар боловсруулж, төсвийн хэмнэгдсэн, хэтэрсэн шалтгааныг тайлбарлан тодруулга бичих. I/25, VII/15, IV/5, VII/15-ны дотор	-Байгууллагын үндсэн болон эргэлтийн хөрөнгийн ашиглалтын үр дүнд ахиц гарч, нягтлан бодох бүртгэлээр тавих хяналт улам сайжирсан байна. -Улсын санхүү болон төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэгдэж бодитойгоор илэрхийлэгдсэн байна.	ТХ

5.14.2015 оны төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг хуульд заасан хугацаанд Төрийн санд гаргах	Төсвийн гүйцэтгэлийн зарцуулалтыг тухай бүрт нь хянаж бүлгийн дүнд хэтрүүлэхгүй байх. I/15-ны дотор	Төсөвт зардал хэтрэхгүй, үр дүнтэй зарцуулагдсан байна.	ТХ
5.15. Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний жил улирал, сарын ерөнхий төлөвлөгөөг боловсруулж Сангийн яаманд хүргүүлэх	Худалдан авах ажиллагааны тайланг Сангийн сайдын 264 дүгээр тушаалын маягт 1-ын дагуу ерөнхий төлөвлөгөөг боловсруулан батлуулж шаардлагатай худалдан авах бараа, ажил үйлчилгээний нэр, төрлийн захиалгыг гаргах. Жилдээ	Тендер үр дүнтэй зохион байгуулагдсан байна.	ТХ
5.16.Төрийн санд байрлах харилцах дансны бэлэн бус болон бэлэн мөнгөний ажил, гүйлгээ, үндсэн хөрөнгө болон бараа материалын орлого, зарлага, няравын тайланг гаргаж нягтлан бодох бүртгэл хөтлөх	а/Анхан шатны баримтын бүрдэл хангагдсан барааны нэхэмжлэл, ажил үйлчилгээний гэрээ, үйл ажиллагаатай холбоотой төсөв, тушаалыг үндэслэн харилцах болон бэлэн мөнгөний өдөр тутмын ажил гүйлгээ хийх. б/Нярваас тайланг гаргуулж хяналт тавьж үлдэгдлийг баталгаажуулах. Жилдээ	Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хууль хэрэгжиж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ахиц дэвшил гарсан байна.	ТХ
5.17.Гадаад, дотоод албан томилолт болон бусад арга хэмжээний төсвийг хянах, батлуулах, тайлан тооцоог хийх	Сангийн сайдын 2011 оны 188, 132 дугаар тушаал, үйл ажиллагаа арга хэмжээний төсвийг газрын болон дэд даргын батласан удирдамжийг үндэслэн төсөв зохиох, хянаж батлуулж, тайлан тооцоог ажилтан алба хаагчдаар гаргуулж авах. Жилдээ	Шатахууныг лимитээс хэтрүүлэхгүй хэрэглэж, автомашин ашиглалтад бүртгэлээр тавих хяналт сайжирсан байна.	СААА
5.18.Эд хөрөнгийн тооллого, засвар, цэвэрлэгээ, үйлчилгээтэй холбоотой багц ажил	Эд хөрөнгө, бараа материалын тооллогыг жилд 2-оос доошгүй удаа хийж, газрын даргын зөвлөлийн хуралд танилцуулах. Жилдээ	-Хуулийн хүрээнд тооллого явагдаж өмчийн ашиглалт, хадгалалтад тавих хяналт сайжирсан байна.	СААА
5.19. Ерөнхий болон автомашины хангамж үйлчилгээ, засвар үйлчилгээтэй холбоотой ажил	а/Дулаан, цахилгаан болон ус хангамжийн системийн их болон урсгал засварыг цаг хугацаанд нь хийж, техникийн горимыг хангуулах, гүйцэтгэлд нь хяналт тавих, мэргэжлийн ханган нийлүүлэгч байгууллагуудтай гэрээ хийж ажиллах.	-Өвлийн улирлын бэлтгэлийг сайтар хангаж, холбогдох байгууллагаар шугам сүлжээгээ хянуулсан байна. -Автомашиныудын бэлэн байдлыг ханган, ажилтан, албан хаагчдад хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхэд дэмжлэг тусалцаа үзүүлсэн байна.	СААА

	б/Автомашины ашиглалтыг сайжруулж, шуурхай ажилд бүх машиныг бэлэн байлгах, үзлэг оношлогоонд хамруулах. Жилдээ		
5.20. Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, нөхөн сэргээх амралт, үйлчилгээнд хамруулах, амрах ая тухтай бичил орчинг дотоод нөөц бололцоог ашиглаж бий болгох, нийгмийн асуудлыг шийдвэрлэх арга замыг эрэлхийлэх	а/Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах үүднээс байгууллагын эмчийн багаж хэрэгсэл, эм тариаг шаардлагын дагуу хангах. б/Ажилтан, албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, албаны бэлэн байдлыг хангах зорилгоор 14 хоног тутам спорт зааланд албаны сургалт явуулах ажлыг зохион байгуулах. в/Амралт (нөхөн сэргээх) сувилалд албан хаагчдыг боломжит хэлбэрээр хамруулах Жилдээ	Ажилтан, албан хаагчдын хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх нөхцөл бололцоо, ажиллах ая таатай орчин бүрдсэн байна.	СААА
Аюулгүй байдал, хяналт шалгалт, нууц, архивын чиглэлээр:			
5.22.Мэдээллийн технологийн чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ	а/Вэб, мэйл сервер, дотоод сүлжээ, ажлын компьютеруудын програм, техник хангамжийн хэвийн ажиллагааг хангах. б/ Байгууллагын телефон утас, харилцаа холбооны хэвийн, найдвартай, тасралтгүй үйл ажиллагааг хангаж ажиллах. в/Төрийн байгууллагуудтай сүлжээгээр холбогдож мэдээлэл солилцох. г/Шаардлагатай байгаа програм хангамж худалдан авах. д/Онлайн хурлын танхимын техникийн бүрэн байдлыг хангах. Жилдээ	-Үйл ажиллагаа тасралтгүй хэвийн явагдсан байна. -Мэдээллийн аюулгүй байдлын түвшин дээшилсэн байна. -Төрийн байгууллага хоорондын мэдээлэл солилцох хурд нэмэгдсэн байна.	АБХШНА

ТАМГЫН ХЭЛТСИЙН ДАРГА, ЭРХЭЛСЭН КОМИССАР

З.БААСАННЯМ